



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/122

Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар баг Эрдэнэзуугийн гудамж 1-78 тоотод байрлах 6209000429 нэгж талбарын дугаартай 5128 м² газрыг 2024 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 01/840 дугаар шүүхийн шийдвэр биелүүлэх мэдэгдэлийн дагуу "Тэргэл нарны туяа ХХК"-д 39 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч "Тэргэл нарны туяа ХХК"-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2020 оны А/119 дугаар захирамж, газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100243